

МОНГОЛ УЛСЫН
ТҮҮГЭЖЛИЙН САЙДЫН ТУХААТ

2016 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 1/54

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, "Зүрх судасны төв, нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил" төсөлтэй уялдуулан Люксембургийн Их Гүнт Улс болон Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох гадаадын 3 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтын дагуу зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Д.Оюунчимэг/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080224

Эрүүл мэндийн
Зөвлөлийн
2016 оны 09 сарын 25 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТИЙН НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

| № | Овог Нэр | Харьялал | Ажиллах байгууллага | Гэрчилгээний серий/дугаар | Төрөлжсөн мэргэшлийн чиглэл | Зөвшөөрлийн төрөл | Хүчинтэй хугацаа |
|----|--|-----------|-------------------------------|---------------------------|-----------------------------|-------------------|-----------------------|
| 1. | Шарпентиер Арнауд Charpentier Arnaud | Франц Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | ГЭ0001652 | Зүрхний мэс засал | Эмчлэх | 2016-09-30 |
| 2. | Филиппе Биллауд Billaud Philippe | Франц Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | ГЭ0001653 | Зүрхний мэс засал | Эмчлэх | 1 хоног 2016-09-30 |
| 3. | Франкус Жулис Леви Levy Francois Jules | Франц Улс | Улсын гуравдугаар төв эмнэлэг | ГЭ0001654 | Мэдээгүйжүүлэг | Эмчлэх | 1 хоног 2016-09-30 |